

I-V ангийн хэл зүй, үгсийн сангийн агуулгын залгамж холбоо

ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН					
Хэл зүй	1.4а. Эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үгсийг ялган таних	2.4а. Хэн юу ямар хэд хэчнээн, яах, яав яасан гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, өгүүлбэр, эх зохиохдоо зөв хэрэглэх	3.4а. Эх өгүүлбэрээс хэн?, юу?, яав?, яаж?, яагаад?, ямар учраас? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, хэрэглэх	4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	5.4а. Эх, өгүүлбэр зохиохдоо хашилт, хаалт, цэг тэмдгийг зөв хэрэглэх
	1.4б. Эх, өгүүлбэр дэх үгсийг хэн? юу? яав? гэсэн асуултаар ялгах	2.4б. Асуусан, хүүрнэсэн өнгө аястай өгүүлбэр зохиохдоо асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх	3.4б. Уншсан эхээс анхааруулах өгүүлбэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх	4.4б. Уриалсан, зөвлөсөн өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	5.4б. Эх, өгүүлбэрт баталсан, дэмжсэн өнгө аясыг илтгэсэн үг, өгүүлбэрийг оновчтой хэрэглэх
Үгийн нөөц	1.4в. Өгүүлбэрийг 1-2 асуултаар дэлгэрүүлэх	"2.4в. Эсрэг утгатай үгийг таних, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх "	3.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	5.4в. Эх, өгүүлбэр зохиохдоо ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэх
		"2.4г. Халц үгийн тайлбарыг уншиж ойлгох, цээжилж тогтоох"	"3.4г. Халц үгийн тайлбарыг уншиж ойлгох, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх "	"4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо халц үгийг утгаар нь зөв хэрэглэх"	"5.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо халц үгийг утгаар нь зөв хэрэглэх"

Эх, өгүүлбэрээс асуултад хариулагдах үгсийг олъя



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг

	асуулт	жишээ
	хэн?	багш, Саран, ээж, өвгөн
	юу?	баавгай, цэцэг, мөндөр, онгоц
	яах? яаж? яав? яадаг?	дэгдэх, суув, уншсан, давхидаг, цэцэглэв, мандсан

1 Ертөнцөд юу юу хөнгөн бэ?, ямар учраас хөнгөн байгааг бодоод, нөхөж бичээрэй.



Урсахад нэг хөнгөн
Хийсэхэд нэг хөнгөн
Өргөхөд нэг хөнгөн

2 Дээрх дасгалын үгсийг асуултын дагуу ангилан бичээрэй.

юу?

яахад?

ямар?

3 Асуултад тохирох үгийг бодоорой.



өргөн,
мөсөн, цасан,
үүлэн Өндөр,
өвсөн

4 “Ертөнцийн гурван давхарга”-ыг хэрхэн бүтээснээ хичээнгүй бичээрэй.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1

“Ертөнцийн гурван хэцүү”-гээс доорх асуултад тохирох үгийг ангилан бичээрэй..

Туухад гахай нэг хэцүү

Тоолоход од нэг хэцүү

Туулахад тал нэг хэцүү

юу?.....

яахад?.....

ямар?


2

Яагаад? Од тоолоход хэцүү вэ? Боломжит хариултыг олж, ✓ тэмдэглээрэй.

о Тэнгэрт хол байдаг учраас

о Тоо нь хязгааргүй их учраас

о Тоолох боломжгүй учраас



3

Яагаад? гахайг туухад хэцүү болохыг тайлбарлаарай.

Туухад

.....

4

“Ертөнцийн гурван сайхан” дахь үгийг асуултын дагуу ялган бичээрэй.

Аав ээжийн сургаал нэг сайхан

Атар газрын цэцэг нэг сайхан

Арван тавны сар нэг сайхан

хэн?	юу?	хэд?	ямар?



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Сануулан, болгоомжлуулж, анхааруулсан утгатай өгүүлбэрийг анхааруулах өгүүлбэр гэнэ. Анхааруулах өгүүлбэрийн эцэст анхааруулах тэмдэг (!) бичнэ. Жишээ нь: Ногоон гэрлээр гараарай!

1 Зөвлөмжийг уншихдаа өгүүлбэрийн төгсгөлийг ажиглаарай.



ЗОГС, ХАР, СОНС буюу зам хөндлөн гарах зөв

дарааллыг хүүхдэдээ тайлбарлах хэрэгтэй []

- Замаас нэг алхмын зайтай зогсож хүлээгээрэй []
- Машин хаанаас ирж байгааг харах хэрэгтэй []
- Машин аль зүгээс ирж байгааг чих тавин сонсоорой []
- Замаар эгц чигээрээ алхаж гарахдаа машиныг анхаарсан хэвээрээ байна шүү []

2 Зөвлөмжөөс анхааруулсан өгүүлбэрийг түүхдээ цэг, тэмдгийг нөхөж хичээнгүй бичээрэй.

Handwriting practice grid with slanted lines for writing.

3 Өгүүлбэрийн төгсгөлд тохирох тэмдгийг тавиад, чанга тод дуугаар хэлж үзээрэй.

Аавын сургаал алт шиг үнэтэй шүү []



Ахаа алд хүндэлж, дүүгээ дэлэм хүндлээрэй []



Алс газарт эрдэм сайн сураад ирээрэй []

Ахмад хүнийг ямагт хүндэлж явах хэрэгтэй []





Сурагчийн нэр: Эхэлсэн: он сарөдөр.....цаг

1 Өгүүлбэрийг хэлэх аялгаар нь зөв харгалзуулж, цэг тэмдгийг нөхөөрэй.

- ? Өвөөдөө тусалдаг сайн хүү юм [] Анхааруулж хэлсэн
- . Чи ахмад настай хүнд тусалдаг уу [] Энгийн хүүрнэн хэлсэн
- ! Өөрөөсөө ахмад хүнийг хүндэлж байгаарай [] Анхааруулж сануулсан
- ! Ахмад настанд тусалж байя [] Асууж хэлсэн

2 Зургийг ажиглаад, хүүхдүүдэд анхааруулах өгүүлбэр бичээрэй.



Цахилгаан хэрэгсэлтэй ажиллахдаа аюулгүйн ажиллагааны дүрмийг баримтлаарай.



Handwriting practice lines for the first illustration.



Handwriting practice lines for the second illustration.

3 Зургийн утгыг илэрхийлсэн анхааруулах өгүүлбэр бичээрэй.



Миний хүү, дугуйгаа унахдаа уруу газар хурдалж болохгүй шүү !



Handwriting practice lines for the third illustration.




Handwriting practice lines for the fourth illustration.




Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сарөдөр.....цаг

Эсрэг ухагдахуун илэрхийлж, утгаараа харилцан эрс өөр үгийг эсрэг утгатай үг гэнэ. Жишээ нь: халуун- хүйтэн, бага – их, эерэг- сөрөг



Дуудлага, бичлэг өөр боловч утгын хувьд адил үгийг ойролцоо утгатай үг гэнэ. Жишээ нь: мэхлэх - хуурах, баяр баясал

1 Зурагтай тохирох эсрэг хос үгийг олж холбоорой.



том - жижиг

муу - сайн

хөөрхөн - муухай

хөгжилтэй - гунигтай

2 Ойролцоо утгатай үгийг олж, өнгө ялган будаарай.

анд

хүчтэй

унтах

нөхөр

чанга

царайлаг

хөөрхөн

нойрсох

3 Ойролцоо, эсрэг утгатай үгийг олж бичээрэй.

хол – ойр

зочлох – айлчлах

өргөн -

хэлэх -

жаргал -

цөөрөх -

урт -

дулаан -

тэгш -

найз -

эрт -

мэдэх -

4 “Том, аварга, нүсэр, агуу, ахмад, сүрлэг” гэсэн ойролцоо үгийн тохирохыг нөхөж бичээрэй.

..... загас хүн уул

..... бүтээл настан биетэй

Ойролцоо болон эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэе



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сарөдөр.....цаг

1 Эсрэг үгийг **шараар**, ойролцоо үгийг **ягаанаар** будаарай.

Мэддэгт мэргэн цоохор	Эрдэмтэй хүн даруу	
Мэддэггүйд эрээн цоохор	Их мөрөн дөлгөөн	
Хол явах гэвэл	Ихийг хийх гэвэл	Далайсан газар далд орох
Ойроос эхэл	Багаас эхэл	Далласан газар ил гарах

2 Амьтдын тухай эсрэгцсэн утгатай өгүүлбэр зохиогоорой.



Ирвэс эсрдэн бэл яст, үзлэсн үздэн.




Blank handwriting practice lines for the second exercise.



Blank handwriting practice lines for the second exercise.

3 Үгсийн эсрэг утгыг олж, үгийн сүлжээг бөглөөрэй.



1. мохоо-
2. зөөлөн -
3. хуурай -
4. нээх -
5. цөөн -

4 Ойролцоо утгатай үгийг өнгө ялган будаарай.

Ш	А	Л	А	М	Г	А	Й	Ц
Ш	С	С	Х	Ү	Ү	Т	Г	Х
И	П	Ч	Ш	У	З	Ч	З	А
Р	Т	Й	Ү	Й	Р	Э	Щ	Р
Т	Х	Ү	Ш	Л	Х	Д	Х	А
Э	Ф	Ц	Р	Ш	С	А	А	Х
Х	Ж	У	Д	Г	П	И	О	Н
Т	О	И	С	В	Э	Ю	Л	Ю
Н	Й	Я	П	Т	Ж	Н	Б	И

хурдан

харах

.....

.....

.....

.....



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



Нэг утга санааг илэрхийлэх бөгөөд аль нэг үгийг нь сольж болдоггүй нийлмэл үгийг хэлц гэнэ. Жишээ нь: цаг барих, магнай тэнийх, амаа барих

1 Дараах нийлмэл үгсийг уншаарай. Ийм байх боломжтой юу? Боломжгүй бол

- | | | | |
|---------------------|--------------------------|--------------------------|--------------------------|
| - тэмдэг тавиарай. | <input type="checkbox"/> | алтан хошуу өргөх | <input type="checkbox"/> |
| нар баруунаас гарах | <input type="checkbox"/> | нүд нь орой дээрээ гарах | <input type="checkbox"/> |
| гар сунгах | <input type="checkbox"/> | | |

2 Дээрх хэлцүүдийг яагаад? болохгүй гэж хариулснаа доор өгөгдсөн өгүүлбэр шиг тайлбарлаж бичээрэй.


Нар ямагт зүүнээс манддаг тул хэзээ ч баруунаас гарахгүй.

Blank handwriting practice lines for the second question.

3 Хэлцийг тайлбартай нь зөв харгалзуулаарай.

- | | | | |
|--------------------------|---|---|---------------|
| нар баруунаас гарах | 0 | 0 | хов зөөх |
| алтан хошуу өргөх | 0 | 0 | гайхах |
| нүд нь орой дээрээ гарах | 0 | 0 | байж болохгүй |
| гар сунгах | 0 | 0 | хүнд туслах |

4 Дээрх дөрвөн хэлц үгээсээ аль нэгийг нь сонгон, өгүүлбэр зохиогоорой.



Дээрх дөрвөн хэлц үг бүгдээрээ үндсэн утга нь өөрчлөгдөн, хэзээ ч биелэхгүй, бүтэхгүй гэсэн далд утга санааг илэрхийлсэн байна.

Blank handwriting practice lines for the fourth question.



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сарөдөр.....цаг

1 Хэлц үгийн доогуур зураарай.

- Ээж маань Солонгосоос ирэх болсныг сонсоод дүүгийн маань нар нь гарч, бид тэр өдрийг тэсэн ядан хүлээж байна.
- Найзуудтайгаа гэртээ өдөржин тоглож өнжихөд цаг хугацаа харвасан сум шиг л өнгөрчээ.
- Чимэг төрсөн өдрөөрөө гэртээ орж ирээд, найзынхаа зассан ширээг хараад ам ангайн зогслоо.
- Аав маань өглөө ажлаасаа бууж ирээд “Нүдний хор гаргая даа” гэж хэлээд өрөө рүүгээ алхав.

2 Хэлцийг тайлбартай нь зөв харгалзуулаарай.

нар нь гарах	0	унтаж амрах
ам ангайх	0	маш хурдан
нохойн дуу ойртох	0	цаг хугацаа дөхөх
харвасан сум шиг	0	гайхаж цочирдох
нүдний хор гаргах	0	баярлаж хөөрөх

3 Хэлцийг тайлбартай нь ижил өнгөөр будаарай.

цаг барих	дотно туслагч
баруун гар	их инээх
алтан хошуу өргөх	яг хэлсэн хугацаанд
элэг хөших	хов зөөх
ам бардам	их ярих
буу халах	бүрэн итгэлтэй байх